БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

# Хялганат тосгоны захирагчийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БУА-2020/17/-СТА-ТТЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Булган хот<br>2020 он | тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр<br>Утас: 70342580<br>Аудитын менежер: Ж.Энхцоодол<br>Утас: 70342716<br>Ахлах аудитор: П.Содном<br>Утас: 70342495 |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

Агуулга

**Аудитын гэрчилгээ** ....................................................................................3
Аудитын тайлан.............................................................................................5
2.1. Оршил .........................................................................................5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ....................5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ..........................5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ..........................6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ........................................6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .................6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .................................6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....................................................6
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.......................................7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.......................................8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..........8
2.13. Шилэн дансны мэдээлэл ....................................................................9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт ..................9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл...............................................................9
Менежментийн захидал ......................................................................................9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .........................................................................12
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.........................................12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .......................................13
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.............................................16
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .........................20
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.................... **Error! Bookmark not defined.**
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.................. **Error! Bookmark not defined.**

## Аудитын гэрчилгээ

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2020.03.25 № 140

танай ____________-ны №____________т

ХЯЛГАНАТ ТОСГОНЫ ЗАХИРАГЧ
Б. УУГАНБАЯР ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хангал сумын Хялганат тосгоны захирагчийн санхүүгийн нэгтгэсэн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Хангал сумын Хялганат тосгоны захирагчийн санхүүгийн нэгтгэсэн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын

0060[illegible]

стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

Аудитын тайлан

**2.1.** Оршил

Хялганат тосгоны захирагчийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Б.Ууганбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хялганат тосгоны захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хялганат тосгоны захирагчийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дүгээр сарын 05-нээс 2020 оны 03 дугаар сарын 25–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Содном хариуцаж хэрэгжүүлэв.

Хялганат тосгоны захирагчийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 03 дүгээр сарын 04-ний өдрийн 01/25 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

**2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хялганат тосгоны үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Иргэдээ дээдэлсэн бүтээлч, чадварлаг төрийн захиргааны байгууллага болоход оршино.

Хялганат тосгоны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төр, эдийн засаг, нийгмийн бодлогын удирдлагын үйл ажиллагаа

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Хялганат тосгоны мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна. /нийцээгүй байна/

Хялганат тосгоны нэгдсэн тайлан нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд  сангийн яамны фрибаланс, СиТиЭйс программ хангамж ашигладаг байна.

Хялганат тосгоны захирагчийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

### 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хялганат тосгоны захирагчийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 3 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

### 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг "дунд/" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 3435299.1 мянган төгрөгөөс  тооцон 68705.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлын түвшингээр тодорхойлоо.

### 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хялганат тосгоны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 21355.4 мянган төгрөгөөр буюу  0.99 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн  данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 12948.5 | 21243.1 | 8294.6 |
| Авлага | 25737.7 | 20008.2 | -5729.5 |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 149541.2 | 161017.7 | 11476.5 |
| Үндсэн хөрөнгө | 3555127.1 | 3533771,7 | -21355.4 |
| **Нийт хөрөнгө** | 3743354.5 | 3736040.7 | -7313.8 |
| Өр төлбөр | 0 | 201.2 | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 3743354.5 | 3735839.5 | -7515.0 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 3743354.5 | 3736040.7 | -7313.8 |

Авлага дансны үлдэгдэл буурсан урьд оны авлагаас барагдуулсан, авлага дансны үлдэгдэлд 2013-2018 онуудад үүссэн, он удаан жил болсон 25737.7 мянган төгрөгийн байгууллагаас авах 4893.8, хувь хүнээс авах 15114.3 авлага байна. Үүнээс зээлдэгч нь нас барсан шалтгааны улмаас барагдах боломжгүй, эрсдэлтэй 1.7 мянган төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь санхүүгийн жилийн эцсээр эргэлтийн хөрөнгө бэлтгэж үлдэгдлээр гаргасан шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд 1990-2019 онд худалдаж авсан ашиглалтгүй 3500.0 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийн бараа материал байна. Оны эцэст 41602.7 мянган төгрөгийн бараа материал болон жижиг хөрөнгө худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн нь үлдэгдэл өссөн харагдахад нөлөөлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь ашиглах хугацаа дууссан буюу цаашид ашиглах боломжгүй үндсэн хөрөнгө акталсан шалтгаалжээ. Хөрөнгө оруулалтаар 312276.2 мянган төгрөг, үүнээс хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан мянган төгрөгийн 219354.8 хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Бусад 201.2 мянган төгрөгийн өр ЭМТ-ийн ЭМД-аас ирэх санхүүжилт дутуу ирснээс шалтгаанаас үүссэн байна.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар хялганат тосгоны захирагчийн ажлын алба тайлант онд 44339.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 47810.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг биелүүлсэн байна.

*Хүснэгт 2.* Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Үйл ажиллагааны орлого | 2100,0 | 3688,7 | -1588,7 | 175,65 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Хөрөнгийн орлого | 9500,0 | 15319,5 | -5819,5 | 161,26 |
| Шууд бус орлого | 16540,0 | 9121,8 | 7418,1 | 55,15 |
| ААН-ийн орлогын албан татвар | 10378,5 | 0 | 10378,5 | 0 |
| Бууны албан татвар | 1971,0 | 1778,0 | 193,0 | 90,21 |
| Улсын тэмдэгтийн хураамж | 4779,0 | 1582,0 | 3196,9 | 33,10 |
| Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 3920,4 | 4986,1 | -1065,7 | 127,19 |
| Хүүгийн орлого | 8000,0 | 10452,6 | -2452,6 | 130,66 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 28500,0 | 44901,6 | -16401,6 | 157,55 |
| Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | 12946,5 | 0 | 12946,5 | 0 |
| Бусад орлого | 1000,0 | 1989,3 | -989,3 | 198,9 |
| Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 1656798,8 | 1656798,8 | 0 | 100,0 |
| **Нийт дүн** | 1756434,2 | 1750618,6 | 5815,6 | 1229,7 |

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 2595387.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 3103677.1 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1656798.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн төсвөөс 276355.6 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Хөрөнгө оруулалтын 5 төсөл, арга хэмжээнд 36835,4 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр .36835,4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

**Нэмэлт төсөв:** Засгийн газрын нөөц сан 15000.0 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 251406.8 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 7662.2 мянга нийт 265594.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

## 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 4 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 62584.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс,707.4 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 57141.4 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 4736.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 10808.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## 2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

...................... ............................................................................................................ авч үзэх нь зүйтэй гэж үзлээ. /анхаарал татахуйц асуудал байхгүй байна./

### 2.13. Шилэн дансны мэдээлэл

Хялганат тосгоны захирагчийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан154 мэдээлэхээс мэдээллийг хугацаанд нь, 30 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, дараа жилийн төсвийн төсөл, худалдан авах ажиллагааны тайлангийн мэдээллийг байршуулаагүй байна.

### 2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 293.3 мянган төгрөгөөр давж биелсэн ч 3 нэр төрлийн орлогыг 9375.0 мянган төгрөгөөр тасалсан, орлогыг нэр төрлөөр авч үзвэл хувь хүний орлогын албан татвар 5781.5, улсын тэмдэгтийн хураамж 2272.0, хүү торгуулийн орлого 1140.0 мянган төгрөгөөр тасарсан бол хөрөнгийн орлого 2936.6, шууд бус орлого 6324.7, хог хаягдлын хураамж 407.0 мянган төгрөгөөр давж биелсэн байна.

Тус тосгоны төсөвт байгууллагуудын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитад хамрагдах хуваарийг 2019 оны 01 дүгээр сарын 07-ын 03 албан тоотоор хүргүүлсэн ч хуваарьт хугацаанаас хоцорсон, хөрөнгийн дахин үнэлгээний ажлыг хугацаанд нь хийгээгүй ажлын хариуцлага сул байна.

Хялганат тосгоны захирагчид гэсэн 2 зөвлөмж өгснөөс зөвлөмжийг хэрэгжүүлж 100 хувьтай байна.

### 2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хялганат тосгоны захирагчийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Хялганат тосгоны захирагчийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

## Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*3.1 Орлогын данстай холбоотой асуудал*

3.1.1 Илрүүлэлт:

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг нийт дүнгээрээ 1107.8 мянган төгрөгөөр давж биелсэн, орлогыг нэр төрлөөр авч үзвэл үйл ажиллагааны орлого 1588.7, хөрөнгийн орлого 5819.5, хог хаягдлын үйлчилгээний хураамж 1065.7, торгуулийн орлого 2452.6, бусад орлого 989.2 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн хэдий ч шууд бус орлого 7418.1, бууны албан татвар 193.0, улсын тэмдэгтийн хураамж 3196.9 нийт 10808.0 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөөг тус тус тасалсан байна.

3.1.2 Эрсдэл:

Төлөвлөөгүй орлого орсноор зориулалт бус зардал гарах, хууль журам зөрчигдөх,

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухай төсвийн байгууллагын өөрийн орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах, жил бүрийн орлогын биелэлтэнд дүн шинжилгээ хийж орлогыг бүрэн төлөвлөх, тасарсан орлого биелэх боломж байгаа эсэх талаар судалгаа хийж байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Саналгүй.

3.2. Төсвийн шууд захирагчтай холбоотой асуудал

*3.2.1 <u>Илрүүлэлт:</u>*

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангаар нийт 62584.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсний 707.4 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоож, 57141.3 мянган төгрөгт албан шаардлага бичиж, зөрчлийг давтан гаргахгүй байх 4736.1 мянган төгрөгийн зөвлөмжийг хүргүүлсэн байна.*<u>3.2.2 Эрсдэл:</u>*

Хууль журам, зөрчигдөх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

*<u>3.2.3</u> <u>Өгсөн зөвлөмж</u>:*

Төсвийн шууд захирагч, санхүү, бүртгэлийн ажилтны сахилга хариуцлагыг сайжруулах, дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах.

*3.2.4 <u>Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Саналгүй</u>*

3.3 Удирдлагатай холбоотой асуудал

*3.3.1 Илрүүлэлт:*

Сумын Засаг дарга нь Боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлэн Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх заалтыг зөрчин цэцэрлэгийн эрхлэгчид Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг дүгнэж үр дүнгийн урамшуулал олгох шийдвэр гаргасан нь Боловсролын тухай хуулийн 30

дугаар зүйлд заасан аймгийн Засаг даргын бүрэн эрхийг хэрэгжүүлсэн зөрчил байна.

*3.3.2 <u>Эрсдэл:</u>*

Хууль журам, зөрчигдөх.

3.3.3 *<u>Өгсөн зөвлөмж</u>:*

Төсөв захирагч нар хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд төсвийг захиран зарцуулах эрх зүйн актыг гаргаж байх.

*3.3.4 <u>Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Саналгүй</u>*

Төсвийн захирагч зөвшөөрсөн Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР Ж.ЭНХЦООДОЛ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР П.СОДНОМ

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

## 1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 188,227,404.69 | 202,269,009.23 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 12,948,512.70 | 21,243,105.39 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 12,948,512.70 | 21,243,105.39 |
| 3121 | Төгрөг | 12,948,512.70 | 21,243,105.39 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 12,948,512.70 | 21,243,105.39 |
| 33 | АВЛАГА | 25,737,716.00 | 20,008,199.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 221,500.00 | 221,500.00 |
| 335 | Бусад авлага | 25,516,216.00 | 19,786,699.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 10,618,367.00 | 4,893,850.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 14,897,849.00 | 14,892,849.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 149,541,175.99 | 161,017,704.84 |
| 351 | Түүхий эд материал | 14,223,292.24 | 14,489,454.69 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 5,976,820.00 | 6,409,740.00 |
| 35130 | Эм боох материал | 8,246,472.24 | 8,079,714.69 |
| 35200 | Дуусаагүй үйлдвэрлэл | | |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 3,512,686.00 | 4,762,586.00 |
| 354 | Хангамжийн материал | 131,805,197.75 | 141,765,664.15 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 21,273,184.00 | 25,994,656.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 61,145,721.15 | 64,939,687.15 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 2,121,200.00 | 1,692,500.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 646,000.00 | 1,245,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 2,470,372.00 | 3,926,300.00 |
| 35460 | Хүнсний материал | 22,628,055.60 | 21,056,256.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 21,520,665.00 | 22,911,265.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 3,555,127,154.64 | 3,533,771,718.70 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 3,555,127,154.64 | 3,533,771,718.70 |
| 391 | Газар | | |
| 392 | Биет хөрөнгө | 3,328,196,703.74 | 3,307,119,767.42 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,235,844,969.29 | 2,445,418,802.29 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (11,197,546.06) | (141,652,091.49) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 260,427,753.48 | 260,427,753.48 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (155,520,935.41) | (192,351,487.09) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 432,021,139.25 | 478,753,079.25 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (225,646,260.70) | (278,926,857.55) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 151,966,413.60 | 184,099,523.60 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (57,320,399.03) | (70,712,181.36) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 1,254,635,741.74 | 1,254,884,941.74 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (563,493,047.42) | (648,995,490.45) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | | |
| 39217 | Ном | 6,478,875.00 | 16,173,775.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 226,930,450.90 | 226,651,951.28 |
| 39301 | Програм хангамж | 2,370,000.00 | 2,370,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,600,299.10) | (1,734,498.92) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 226,521,500.00 | 226,521,500.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (360,750.00) | (505,049.80) |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 3,743,354,559.33 | 3,736,040,727.93 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | - | 201,206.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | 201,206.00 |
| 413 | Өглөг | - | 201,206.00 |
| 4136 | Бусад өглөг | - | 201,206.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 201,206.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 3,743,354,559.33 | 3,735,839,521.93 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 3,743,354,559.33 | 3,735,839,521.93 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 3,505,149,130.73 | 3,714,722,963.73 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | (771,405,778.21) | (988,494,648.61) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,228,871,946.76 | (771,405,778.21) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (3,000,277,724.97) | (217,088,870.40) |
| 51230 | Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс | | |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,009,611,206.81 | 1,009,611,206.81 |
| 51400 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | |
| 51500 | Бодлогын өөрчлөлт алдааны залруулга | | |
| 51600 | Нөөцийн сан | | |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 3,743,354,559.33 | 3,736,040,727.93 |

## 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,640,541,118.12** | **3,218,210,203.95** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **34,541,857.41** | **36,476,288.59** |
| **110** | **Орлогын албан татвар** | 25,919,857.41 | 28,130,076.59 |
| **1100** | **Хувь хүний орлогын албан татвар** | 25,919,857.41 | 28,130,076.59 |
| 110002 | Үйл ажиллагааны орлого | | 3,688,700.00 |
| 110003 | Хөрөнгийн орлого | | 15,319,509.44 |
| 110005 | тэдгээрт оролцож олсон орлого, тэргээртэй адилтгах бусад орлого | 14,295,160.81 | - |
| 110008 | Шууд бус орлого | 11,624,696.60 | 9,121,867.15 |
| **113** | **Хөрөнгийн албан татвар** | 1,387,000.00 | 1,778,000.00 |
| 113001 | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | | |
| 113002 | Бууны албан татвар | 1,387,000.00 | 1,778,000.00 |
| **118** | **Бусад татвар, төлбөр, хураамж** | 7,235,000.00 | 6,568,212.00 |
| **1180** | **Бусад нийтлэг төлбөр, хураамж** | 7,235,000.00 | 6,568,212.00 |
| 118001 | Улсын тэмдэгтийн хураамж | 2,128,000.00 | 1,582,040.00 |
| 118009 | Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 5,107,000.00 | 4,986,172.00 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **122,843,525.18** | **104,288,326.36** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 122,843,525.18 | 104,288,326.36 |
| 120002 | Хүүгийн орлого | 9,272,023.00 | |
| 120003 | Торгуулийн орлого | | 10,452,670.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 112,752,962.18 | 78,121,375.26 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 24,664,027.00 | 22,137,493.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 57,017.00 | 25,421,300.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 88,031,918.18 | 30,562,582.26 |

| | | | |
|---|---|---|---|
| 120009 | Бусад орлого | 818,540.00 | 15,714,281.10 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,483,155,735.53** | **3,077,445,589.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,869,317,300.00 | 1,656,798,800.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,869,317,300.00 | 1,656,798,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 74,644,233.10 | 244,206,832.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 9,151,823.10 | |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 17,630,000.00 | 230,124,082.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 18,333,260.00 | 14,082,750.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 29,529,150.00 | |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 539,194,202.43 | 1,161,429,367.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 275,649,900.00 | 835,681,907.00 |
| 132003 | Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/ | 10,362,102.43 | 14,556,560.00 |
| 132006 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/ | 221,892,600.00 | 276,355,600.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 31,289,600.00 | 34,835,300.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | - | 15,010,590.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | | 15,010,590.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,953,353,395.52** | **3,435,299,074.35** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,953,353,395.52** | **3,435,299,074.35** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,583,187,433.09 | 3,052,734,957.54 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,174,254,499.50 | 1,414,633,769.19 |
| 210101 | Үндсэн цалин | 863,791,794.50 | 1,042,950,628.00 |
| 210102 | Нэмэгдэл | 196,337,541.00 | 227,883,785.43 |
| 210104 | Урамшуулал | 81,047,464.00 | 122,584,955.76 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 33,077,700.00 | 21,214,400.00 |
| 210106 | Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 142,623,955.43 | 177,301,303.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 96,355,003.43 | 120,943,668.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,587,334.00 | 14,160,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,258,991.00 | 11,221,113.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,292,286.00 | 2,980,548.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 23,130,341.00 | 27,995,074.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол** | 512,095,020.00 | 519,741,472.00 |

| | | | |
|---|---|---|---|
| | **зардал** | | |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 26,009,347.00 | 29,984,797.00 |
| 210302 | Түлш, халаалт | 464,248,273.00 | 465,963,075.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 21,837,400.00 | 23,793,600.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 42,718,469.00 | 64,138,073.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,490,740.00 | 6,187,063.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,576,400.00 | 27,228,670.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,133,050.00 | 4,370,469.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 105,938.00 | 821,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,636,100.00 | 3,161,250.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 11,085,441.00 | 21,092,259.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 1,690,800.00 | 1,276,762.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 129,882,403.61 | 140,737,238.41 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 19,632,075.81 | 36,295,983.81 |
| 210502 | Хоол, хүнс | 101,101,197.80 | 101,536,804.60 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 9,149,130.00 | 2,904,450.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 15,741,365.00 | 16,698,980.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 341,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | 469,580.00 |
| 210604 | Урсгал засвар | 15,741,365.00 | 15,888,400.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,731,500.00 | 10,760,100.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,731,500.00 | 10,760,100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 19,103,096.00 | 33,547,405.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 18,140,171.00 | 32,191,748.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 102,800.00 | 490,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 545,917.00 | 327,280.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 131,400.00 | 239,677.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 51,000.00 | 200,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | |
| 210807 | Газрын төлбөр | 111,808.00 | 98,700.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 20,000.00 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 542,037,124.55 | 675,176,616.94 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 109,943,247.10 | 330,564,380.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 12,882,485.00 | 16,196,118.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 419,211,392.45 | 328,416,118.94 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 370,165,962.43 | 382,564,116.81 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 77,162,714.00 | 30,027,280.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | 1,068,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 27,094,714.00 | 25,856,280.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 23,238,000.00 | |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 21,780,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,050,000.00 | 3,103,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 4,000,200.00 | - |
| 213305 | нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг | 4,000,200.00 | |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 286,259,302.43 | 346,432,329.00 |
| 213401 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага | 275,649,900.00 | 331,540,807.00 |
| 213402 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад | | |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,362,102.43 | 14,891,522.00 |
| 213405 | нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг | 247,300.00 | |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,743,746.00 | 6,104,507.81 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,743,746.00 | 6,104,507.81 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(312,812,277.40)** | **(217,088,870.40)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 2,687,475,447.57 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 1,852,830,925.79 | |
| 225007 | Хөрөнгийн дахин үнэлгээний зардал | 834,644,521.78 | |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (2,687,475,447.57) | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(3,000,287,724.97)** | **(217,088,870.40)** |

## 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2560015290.94** | **3192652621.69** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **34541857.41** | **36476288.59** |
| **110** | **Орлогын албан татвар** | 25919857.41 | 28130076.59 |
| **1100** | **Хувь хүний орлогын албан татвар** | 25919857.41 | 28130076.59 |
| 110002 | Үйл ажиллагааны орлого | 2,248,544.00 | 3,688,700.00 |
| 110003 | Хөрөнгийн орлого | 12,046,616.81 | 15,319,509.44 |
| 110008 | Шууд бус орлого | 11,624,696.60 | 9,121,867.15 |
| **113** | **Хөрөнгийн албан татвар** | 1387000.00 | 1778000.00 |
| 113002 | Бууны албан татвар | 1,387,000.00 | 1,778,000.00 |
| **118** | **Бусад татвар, төлбөр, хураамж** | 7235000.00 | 6568212.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **1180** | **Бусад нийтлэг төлбөр, хураамж** | 7235000.00 | 6568212.00 |
| 118001 | Улсын тэмдэгтийн хураамж | 2,128,000.00 | 1,582,040.00 |
| 118009 | Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 5,107,000.00 | 4,986,172.00 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **42317698.00** | **57343544.10** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 42317698.00 | 57343544.10 |
| 120002 | Хүүгийн орлого | 9,272,023.00 | |
| 120003 | Торгуулийн орлого | | 10,452,670.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 32227135.00 | 44901593.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 32,227,135.00 | 19,480,293.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 25,421,300.00 |
| 120009 | Бусад орлого | 818,540.00 | 1,989,281.10 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2483155735.53** | **3098832789.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1869317300.00 | 1656798800.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,869,317,300.00 | 1,656,798,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 74644233.10 | 265594032.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 9,151,823.10 | |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 17,630,000.00 | 230,124,082.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 18,333,260.00 | 27,807,750.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 29,529,150.00 | 7,662,200.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 539194202.43 | 1161429367.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 275,649,900.00 | 835,681,907.00 |
| 132002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | | |
| 132003 | Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/ | 10,362,102.43 | 14,556,560.00 |
| 132006 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/ | 221,892,600.00 | 276,355,600.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 31,289,600.00 | 34,835,300.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 0.00 | 15010590.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | | 15,010,590.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2498591673.10** | **3103677079.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2498591673.10** | **3103677079.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2128358524.67** | **2685503942.19** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1175851638.00 | 1414633769.19 |
| 210101 | Үндсэн цалин | 857,111,414.00 | 1,042,950,628.00 |
| 210102 | Нэмэгдэл | 199,072,441.00 | 227,883,785.43 |
| 210104 | Урамшуулал | 80,957,464.00 | 122,584,955.76 |

| | | | |
|---|---|---|---|
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 38,710,319.00 | 21,214,400.00 |
| 210106 | Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 140861112.57 | 177244286.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 94,263,313.57 | 120,943,668.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,668,834.00 | 14,160,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,323,791.00 | 11,164,096.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,311,386.00 | 2,980,548.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 23,293,788.00 | 27,995,074.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 509062392.00 | 520340700.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 26,009,347.00 | 29,984,797.00 |
| 210302 | Түлш, халаалт | 461,215,645.00 | 466,562,303.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 21,837,400.00 | 23,793,600.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 36391000.00 | 59351039.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,566,100.00 | 4,696,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,596,400.00 | 27,228,670.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,587,000.00 | 4,370,469.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 635,000.00 | 766,100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,838,700.00 | 2,531,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,167,800.00 | 19,758,100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 134316809.00 | 139750735.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 22,749,400.00 | 27,350,100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 105,653,109.00 | 99,965,005.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,914,300.00 | 12,435,630.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 21140365.00 | 18852680.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 948,000.00 |
| 210602 | Тавилга | 1,065,000.00 | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | 469,580.00 |
| 210604 | Урсгал засвар | 20,075,365.00 | 17,435,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4731500.00 | 10760100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,731,500.00 | 10,760,100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 22430325.00 | 34099230.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 21,433,100.00 | 32,743,573.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 102,800.00 | 490,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 553,717.00 | 327,280.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 134,400.00 | 239,677.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 67,000.00 | 200,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 119,308.00 | 98,700.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 20,000.00 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 83573383.10 | 310471403.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 68,491,283.10 | 287,051,253.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 15,082,100.00 | 23,420,150.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **370233148.43** | **418173136.81** |

| | | | |
|---|---|---|---|
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 0.00 | 36835300.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | | 36,835,300.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 77229900.00 | 28801000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | 1,068,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 27,161,900.00 | 24,630,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 23,238,000.00 | |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 21,780,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,050,000.00 | 3,103,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 4000200.00 | 0.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4000200.00 | |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 286259302.43 | 346432329.00 |
| 213401 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага | 275,649,900.00 | 331,540,807.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,362,102.43 | 14,891,522.00 |
| 213404 | Хөрөнгийн | 247,300.00 | |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2743746.00 | 6104507.81 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,743,746.00 | 6,104,507.81 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **61423617.84** | **88975542.69** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **52059000.00** | **75680950.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **52059000.00** | **75680950.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 52059000.00 | 75680950.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 31,289,600.00 | |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 20,769,400.00 | 75,680,950.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-52059000.00** | **-75680950.00** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | 7565000.00 | 5000000.00 |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 7,565,000.00 | 5,000,000.00 |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-7565000.00** | **-5000000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 1799617.84 | 8294592.69 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 11148894.86 | 12948512.70 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 12948512.70 | 21243105.39 |

## 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 3,279,349,130.73 | 623,776,209.26 | 2,169,728,428.44 | 6,072,853,768.43 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 59,143,518.32 | 59,143,518.32 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **3,279,349,130.73** | **623,776,209.26** | **2,228,871,946.76** | 6,131,997,286.75 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | 385,834,997.55 | | 385,834,997.55 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 225,800,000.00 | | | 225,800,000.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | (3,000,277,724.97) | (3,000,277,724.97) |
| C08 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **3,505,149,130.73** | **1,009,611,206.81** | **(771,405,778.21)** | 3,743,354,559.33 |
| D01 | **2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **3,505,149,130.73** | **1,009,611,206.81** | **(771,405,778.21)** | 3,743,354,559.33 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **3,505,149,130.73** | **1,009,611,206.81** | **(771,405,778.21)** | 3,743,354,559.33 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 209,573,833.00 | | | 209,573,833.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | (217,088,870.40) | (217,088,870.40) |
| D09 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **3,714,722,963.73** | **1,009,611,206.81** | **(988,494,648.61)** | 3,735,839,521.93 |